

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 08 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 08 дугаар сарын 20-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>2</i>

<i>1.Горимын санал</i>	<i>2</i>
-------------------------------	-----------------

Монгол Улсын Их Хурлын “Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 42 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Б.Баярбаатар, Б.Жаргалан, Д.Пүрэвдаваа, Ө.Шижир;

Нэг.Хянан шалгах түр хорооны хянан шалгагчийг томилох

Хоёр.Оюу Толгой төсөл, үйл ажиллагааны талаарх мэдээлэл танилцуулга сонсох

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн Түр хорооны дарга О.Батнайрамдал дээрх асуудлуудыг хаалттай хуралдаанаар хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

О.Батнайрамдал: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	6
Татгалзсан	-
Бүгд	6

100.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдаан 11 цаг 44 минутад хаалттай горимд шилжив.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

О.БАТНАЙРАМДАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 08 дугаар сарын 20-ны өдөр

Лхагва гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхимд 11 цаг 02 минут

**ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

О.Батнайрамдал: Эрхэм гишүүддээ энэ бороотой өдрийн амар амгаланг айлтгая. Оюутолгой бүлэг ордын ашиглалтын асуудлаарх Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул 2025 оны 8 сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийн ирцийг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар, Пүрэвжавын Ганзориг, Шинэбаярын Бямбасүрэн, Энхбатын Болормаа, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Отгоншарын Батнайрамдал гэсэн гишүүдийн ирцээр хуралдаан маань эхэлж байна аа.

Өнөөдөр бид нар 2 асуудалтай байгаа.

Хянан шалгах түр хорооны хянан шалгагчийг томилох,

Хоёрдугаарт Оюу Толгой төсөл, үйл ажиллагааны талаарх мэдээлэл танилцуулга сонсоно.

Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Өнөөдрийн асуудал дээр Хянан шалгах түр хорооны хянан шалгагч томилохтой, мэдээлэл авахтай холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн хуралдааныг хаалттай горимд шилжүүлэн хуралдахаар горимын саналын санал хураалт явуулъя.

Энэ 2 асуудалтай холбоотойгоор хаалттай хуралдъя гэсэн санал гаргаж байна аа.

Гишүүд санал хураалтад бэлдье.

Санал хураалт. Гишүүдийн 100 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдааныг хаалттай горимд шилжүүлнэ үү.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

